

I-V/2021


Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 13



Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 2796 (23.0%) -аар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 5 сард 9369 болж, өмнөх оны мөн үеэс 2796 (23.0%)-гаар буурчээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2494 (34.3%), хулгайлах гэмт хэрэг 2011 (59.1%), мал хулгайлах гэмт хэрэг 336 (49.3%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 207 (6.7%), дээрэмдэх гэмт хэрэг 135 (54.7%), хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 117 (32.1%)-аар, хөрөнгө завших гэмт хэрэг 115 (43.1%)-аар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 203 (2.4 дахин)-аар өссөн байна. 2021 оны 5 дугаар сард 1706 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 638 (27.2%)-аар буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 510 (38.1%), залилах хэрэг 264 (38.7%), хулгайлах хэрэг 149 (37.9%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 596 хэргийн 61 (10.2%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2021 оны эхний 5 сард 61 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14 (29.8%)-өөр өсжээ. Харин 2021 оны 5 дугаар сард 20 бүртгэгдсэн нь өмнөх сараас 9 (81.8%)-өөр өссөн байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2021 оны эхний 5 сард 4115 зөрчил бүртгэгдсэний 2975 (72.3%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 858 (17.3%)-аар, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 857 (22.4%)-гоор тус тус буурчээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 5 сард 44 болж, өмнөх оны мөн үеэс 13 (22.8%)-аар буурсан байна. Харин 2021 оны 5 дугаар сард өмнөх сараас 3 (27.3%)-аар буурчээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг 2021 оны эхний 5 сард 596 болж, өмнөх оны мөн үеэс 129 (27.6%)-өөр, эмэгтэй хүн оролцсон хэрэг 1322 болж, 65 (5.2%)-аар нэмэгдэж, харин согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 1742 болж, өмнөх оны мөн үеэс 19 (1.1%)-өөр, бүлэглэн үйлдсэн хэрэг 510 болж, 214 (29.6%)-өөр, хүүхэд оролцсон хэрэг 217 болж, 23 (9.6%)-аар, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 68 болж, 4 (5.5%)-өөр тус тус буурчээ.

Зураг 2. Учирсан хохирол, нөхөн төлүүлсэн хохирол, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2021 оны эхний 5 сард 74.0 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 21.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 2.9 (3.8%) тэрбум төгрөгөөр буурч, харин нөхөн төлүүлсэн хохирол 5.2 (32.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Гэмт хэргийн улмаас хохирсон, гэмтсэн, нас барсан хүн, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар


Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2020 I-V	2021 I-V	2020 I-V	2021 I-V	2020 I-V	2021 I-V
7 хүртэлх	61	56	18	23	33	18
8-17	410	335	127	114	13	8
18-29	2 981	2 363	1 017	862	41	39
30-39	3 862	2 959	1 078	1 010	60	62
40-49	2 493	1 901	602	585	76	62
50-59	1 419	916	328	300	63	45
60-69	492	308	85	73	32	15
70, түүнээс дээш насны	98	91	13	31	7	8
Улсын дүн	11 816	8 929	3 268	2 998	325	257
Эмэгтэй	4964	4066	1 259	1 152	87	65

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2021 оны эхний 5 сард 8.9 мянга болж, 391 (4.4%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 4066 (45.5%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний 5 сард 2998 хүн гэмтэж, 257 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 270 (8.3 %) -аар, нас барсан хүн 68 (20.9%)-аар буурчээ.

Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний 5 сард хохирсон 8929 хүний 56 (0.6%) нь 7 хүртэлх насных, 335 (3.8%) нь 8-17 насных, 2363 (26.5%) нь 18-29 насных, 2959 (33.1%) нь 30-39 насных, 1901 (21.3%) нь 40-49 насных, 1315 (14.7%) нь 50, түүнээс дээш насныхан байна.

Зураг 3. Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, насны бүлгээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2021 оны эхний 5 сард 6043 болж, өмнөх оны мөн үеэс 547 (8.3%)-гоор бүүрчээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 245 (4.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 1027 (17.0%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэрэгт 2021 оны эхний 5 сард холбогдсон нийт 6043 яллагдагчийн 73 (1.2%) нь 14-15 насных, 172 (2.8%) нь 16-17 насных, 2351 (38.9%) нь 18-29 насных, 1786 (29.6%) нь 30-39 насных, 1192 (19.7%) нь 40-49 насных, 469 (7.8%) нь 50, түүнээс дээш насных байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард 28.5 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 5.7 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 14.8 (34.2%) мянгаар, баривчлагдсан хүн 1200 (17.3%)-гаар буурсан байна.


Авлигатай тэмцэх газарт 2021 оны эхний 5 сард 154 авлигын хэрэг бүртгэгджээ.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2021 оны эхний 5 сард авлигын 154 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 (6.1%)-аар бүүрчээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс буурахад хахууль өгөх гэмт хэрэг 10 (58.8%)-аар, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг 7 (77.8%)-гоор, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 4 (3.3%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Харин 2021 оны 5 дугаар сард 25 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 23 (47.9%)-аар буурсан байна. Бүртгэгдсэн авлигын хэрэг өмнөх сараас буурахад эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 11 (35.5%)-ээр, хахууль авах гэмт хэрэг 9 (75.0%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 154 авлигын хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 117 (74.1%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 27 (17.1%) нь хахууль авах гэмт хэрэг, 7 (4.4%) нь хахууль өгөх хэрэг, 2 (1.3%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 5 (3.2%) хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна.

Зураг 4. Авлигын гэмт хэрэг, хэргийн төрлөөр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Авлигын гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, Авлигатай тэмцэх газрын мэдээлэл



Ангилал, код: Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

Мэдээлэл авах линк:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын статистикч Ц.Дулмаа
Утас: (976-51)-263966*